

**Сэнгэдоржийн Түмэндэлгэр
МУБИС-ийн Нийгмийн Ухааны тэнхмийн багш**

**Сэдэв: Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт
терийн бодлого**

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлийн санаа нь соёлын янз бүрийн загвараар тодорхойлогдсон төрийн бодлогууд нь эмэгтэйчүүдийн хөлсний хөдөлмөр эхлэлтийн ялгаатай дүр зургийг нөхцөлдүүлдэг гэсэн онолын дүгнэлтээс үүдэлтэй юм. Төрийн халамжийн бодлогын хэв маягууд нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй хэрхэн холбогддог талаархи Европид хийгдсэн харьцуулсан судалгаануудын загвар тулгуурлах замаар эрх зүйн актуудад анализ хийсний үр дүнд Монголын төрийн халамжийн бодлогын хэв маягийг тодорхойлон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж болох талаар өгүүлнэ.

Түлхүүр үт: нийгмийн бодлого, нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл

Нэг. Удиртгал

1990-ээд оноос хойш эмэгтэйчүүдийн нийгмийн байдал, жендерийн ялгаатай байдлыг тодруулах хэд хэдэн судалгаануудад төрийн бодлого дахь жендерийн мэдрэмжтэй байдал дутагдаж байна гээд жендерийн мэдрэмжтэй судалгаа шинжилгээний ажил хийхийг чухалчилжээ. (Берн Н, нар, 2001, ДБ, АХБ, 2004).

Европын орнуудад хийгдсэн харьцуулсан судалгаанууд нь улс орнуудын халамжийн бодлогуудын ялгаатай байдал нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай дур төрхийг авчирч байгааг тогтоожээ (Кромптон. Р 1998, Дункан. С 1994, Пфеу-Эффингэр. Б 1998). Социалист төрийн халамжийн бодлого нь "ажиллагч" эмэгтэйчүүдийн загварыг бүрдүүлэхэд чухал нөлөөтэйг судалгаанууд тогтоогоод (Поллерт. А, 2003) байгаа боловч Монгол улсад уг бодлого орвонгоороо өөрчлөгдөөд нэлээдгүй хугацаа өнгөрчээ. Иймээс судлаач бидний өмнө өнөө цаг үеийн төрийн халамжийн бодлого нь ямар загвараар төлөвшиж байгаа, уг бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд ямар нөлөө үзүүлж байна вэ гэсэн асуудлууд дэвшигдэж байна.

Энэхүү шаардлагын үүднээс миний бие энэхүү өгүүлэлдээ төрийн халамжийн бодлогын хэв маягууд нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй хэрхэн холбогддог талаарх өрнөдийн судлаачдын онол үзэл баримтлал, харьцуулсан судалгаануудын үр дүнгүүдийг авч үзсэний дараагаар эрх зүйн актуудад анализ хийсний үр дүнд Монголын төрийн халамжийн бодлого нь Е.Андерсений боловсруулсан ангилалтын аль хэв маягт багтаж байгааг болон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж болохыг авч үзэхийг зорилоо.

Хоёр. Европын орнуудын төрийн халамжийн бодлого ба эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт

Ер нь төрийн бодлого нь зориуд биш байдлаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх сонирхлын эсрэг байж болдог аж. Түүхэн дэх ихэнх төрүүд нь эмэгтэй хүнд "тэрийн эзэгтэй, эх хүн" гэдэг утгаар нь гол анхаарлаа хандуулсан бодлого баримталж байжээ.

Ялангуяа хүн амын талаар буюу төрөлтийн талаар баримтлах төрийн нийгмийн бодлого нь эмэгтэйчүүдийн хөлсний хөдөлмөр эрхлэх явдалд нөлөө үзүүлдэг аж. Уламжлалт нийгмийн үед төрүүд хүн амаа үйлдвэрлэх хүч гэж үзэн хэрэв эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэхгүй бол тэр иргэнгүй болж ажил

олгогчид ажилчидгүй болно гэсэн үүднээс эх байхыг тулгангүй хандаж байсан бол орчин үеийн төрүүд нь эх болох буюу нөхөн үргижүйн эрхийг эмэгтэйчүүдэд олгон, хуульчлах болжээ. Өнөөдөр төрүүд хүн амын өсөлтийн талаар ялгаатай бодлого баритмталж байгаа бөгөөд тодруулбал зарим төр нь хүн амын өсөлтөд хяналт тавьж байхад (Хятад гэх мэт), зарим нь эсрэгээр төрөлтийг дэмжсэн бодлого барьж байна (Франц, Чех гэх мэт).

Өөр нэг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдож буй төрийн бодлогын аспект нь хүүхдийн эрүүл мэндийн асуудалд хэрхэн хандаж байгаа явдал. Ихэнх нийгмүүдэд хүүхдийн эрүүл мэндэд гол анхаарал тавигч нь түүний ЭЭЖ гэж үзэх нь хэвээр байна. Үүнтэй холбоотойгоор заж, болон хүүхдэд чиглэсэн бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн дүр зурагт нөлөөлдөг байна (Кромптон. Р 1998). Гэхдээ энэ нь эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт шууд, хэлсгүй хөдөлмөрт дам байдлаар налее үзүүлдэг аж (Бжурнберг. Б, 2002).

Феминистууд төрийн халамжийн бодлого нь гэр бүлийг "Эр хүн тэжээгч" загвараар авч үзэн тодорхойлж байна гэж үзээд тэрхүү загварыг өөрчлөхийг шаарддаг. Яагаад тэд энэхүү дүгнэлтэд хүрсэн болохыг ойлгохын тулд юуны өмнө дэлхийн улсуудын Төрийн халамжийн бодлогыг хэрхэн ангилж судалсан тухайд анхаарлаа хандуулъя.

Еспинг Андерсен (1990) төрийн халамжийн бодлогыг З ангилсан байдаг.

1. Социаль демократ (Скандиновын орнуудын). Бүх иргэд нь төрийн тусlamж дэмжлэгийг адил тэгшээр эдлэх эрхтэй хамзээдэг нь нийгэмд тэгш байдал тогтооход чухал нөлөөлж байна.
2. Корпоратист (Франц, Герман, Итали г.м). Даатгалын эрхэд тулгуурласан бөгөөд тэтгэмж нь цалингийн ялгаатай холбогддог. Энэ нь дахин хуваарилах буюу тэгш байдлыг тогтооход нөлөө баатай аж.
3. Либераль (Англи, АНУ г.м). Халамжийн тэтгэмж нь хэрэгтэй гэгдэх хүндээ л олгогддог буюу даатгалтай хүн хүртэх эрхтэй, өөрөөр хэлбэл зах зээлийн харилцааны шинжтэй. Тэтгэмж олгох үйлчилгээ нь хувийн секторт байдаг. Түүнийг нь төр нь дэмжих байдаг. Энэ төрийн хувьд дахин хуваарилалт гэж байхгүй бөгөөд тэгш байдлыг тогтоох боломжоор хомс.

Нэлээд судлаачид Е. Андерсений дээрх хэв маяг бүхий халамжийн бодлогууд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн налее үзүүлж байгааг судалсан байдаг.

Европын орнуудаас либераль хэв маяг багтдаг бодлого бүхий орон бол Британи юм. Британий төр хүүхэд асарсны тэтгэмж болон бусад төрлийн тусlamж дэмжлэгийг ажил эрхэлж буй эмэгтэйчүүдэд өгөх талаар учир дутагдалтайн зэрэгцээ хүүхэд асрах үйлчилгээгээрээ Европод хамгийн доогуур юм байна. Ажил эрхлэгч эмэгтэйчүүдэд хүүхдээ асуулах хэрэгцээ байгааг төрөөс илүү хувийн сектор, ажил олгогчид мэдэрч үйлчилгээний байгууллага байгуулж эхэлсэн байна. Ийм байлаа ч тэд шууд ажилд орох нь бага хэвээр байгаа аж (Кромптон. Р 1998).

Корпоратист бодлого бүхий орнуудад Франц, ХБНГУ зэрэг орнууд багтдаг. Францад Британиас эсрэгээр хүүхэд төрүүлэх, асрахыг дэмжсэн бодлоготой. Францын эмэгтэйчүүд ба гэр бүлийг дэмжих бодлого нь нилээд өөрчлөгдөж байна. Францын нялхыг хамгаалах 19-р зуунаас эхэлсэн бодлого нь хүүхэд төрүүлснийхээ дараа маш хурдан ажилдаа буцаж орж байгаа асуудалтай тулгарад байгаа аж. Учир нь хүүхэдтэй холбогдох ихэнх зардлыг төр хариуцдаг бөгөөд энэ нь ажил эрхэлж байсан ч үргэлжилдэг тул хүүхдээ асрах, ажиллах 2-ыг хослуулах боломжийг Францад эмэгтэйчүүдэд олгож байна (Кромптон. Р 1998). Мөн түүнчлэн Европын бусад орнуудтай

харьцуулахад хүүхэд асрахад өгч байгаа тэтгэмжийн хэмжээ өндөр бөгөөд 3 нас хүртэл нь хүүхдэд асаргааны тэтгэмжийг олгодог байна.

Германы халамжийн төр нь нийгмийн бүлгийн харьяалал, нийгэмд эзэлж буй статустай холбогдог тул дахин хуваарилалт бага хийгддэг. Хөлстэй хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг төр маш хязгаарлагддаг байдлаар дэмждэг. Хөлстэй ба хөглигүй хөдөлмөрийг хослуулан цагийн хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдэд хүүхэд асаргааны тэтгэмж олгох бодлого нь учир дутагдалтай байдаг тул дэмжлэг багатай бодлогод ордог байна. Мөн түүнчлэн цагийн хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн нийгмийн даатгалын асуудлыг зарим фирмүүд шийдэлгүйгээр орхигдуулдаг юм байна. 1980-аад оноос нийтийн зарим асуудлыг шийдэлгүйгээр орхигдуулсан ч хүүхэд гэрт өсөх нь маш хүүхэд асрах байгууллагуудыг олноор байгуулсан ч хүүхэд асрах байгууллагаар чухал зүйл гэсэн үзэл суртал хүчтэй байдаг тул хүүхдээ асрах байгууллагаар асууллагчдын тоо цөөн ажээ. Ийнхүү Германы төрийг эмэгтэйчүүдийг хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжийг олгох байдлаар учир дутагдалтай хэмээн судлаачид дүгнэдэг байна (Пфау-Эффингэр. Б 1998).

Чех улс нь социалист бодлоготой байсан орон. 1971 оноос эх болсны тэтгэмж, хүүхэд төрүүлсэн хосуудад эхний дугаарт байр олгодог, хосуудыг гэр булийн зээлээр дэмжиж байжээ. Харин хүүхэд асарсны тэтгэлэг нь бусад социалист гэгдэгч орнуудынхаас доогуур байсан байна. Эх байх ба ажил эрхлэх хоёрыг хослуулах нь хялбар биш байсан боловч эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж чадсан бөгөөд гэвч гэрийн хөдөлмөрийн ачаалал өндөр хэвээр байдаг аж (Кромптон. Р 1998).

Норвеги нь жендерийн тэгш байдлыг тогтооход чиглэж байгаагаараа бусад Скандиновын орнуудтай төстэй байгаа ч зарим талаараа ялгаатай юм байна. Харин гэрийн хөдөлмөрийг ажил гэж тооцдогоороо дэвшилттэй. Учир нь хүүхэд асрах гэж хөдөлмөрийн зах зээлээс гарсныг тэтгэмжийн схемд оруулдаг. Хэрэв өвчтэй хүүхэд асарсан бол эцэг эх хоёуланг нь ажилласанд тооцож тэтгэврийн схемд оруулдаг байна (Кромптон. Р 1998).

Нидерланд мөн адил Скандиновын орнуудын нэгэн адил социаль демократ халамжийн бодлоготой. Даатгуулсан, даатгуулаагүй, татварт их, бага мөнгө төлснөөс үл хамааран бүх иргэд нийгмийн халамжаас адил тэгш хүртэх гэсэн дахин хуваарилалтыг чухалчилсан бодлоготой. Хөлстэй хөдөлмөр дэх эмэгтэйчүүдийн оролцоог төдийгүй хелсгүй хөдөлмөр дэх жендерийн тэгш оролцоог онцгой анхаардаг. Цагийн хөдөлмөрийн ажлын нөхцлийн стандарт, нийгмийн хамгааллын талаар дэмжих бодлого баримталж байна (Пфау-Эффингэр. Б 1998).

Ажлын хөлсний хэмжээний хувьд Франц улсад эмэгтэйчүүдийн цалин эрэгтэйчүүдийн цалингийн 80%, Чех мөн адил, Их-Британид хамгийн (Европийн орнууд дотроо) бага хувьтай тэнцэх цалинг эмэгтэйчүүд авдаг байна. Харин Францад цагийн хөдөлмөр эрхлэлт нь бага байна. Хагас цагийн хөдөлмөр эрхлэх явдал Чехэд бараг байхгүй, Англи болон Норвеги, Герман, Нидерландад бүгдэд нь өндөр байдаг аж. Нидерландад хамгийн сонирхолтой нь эрэгтэйчүүд цагийн хөдөлмөрийг эмэгтэйчүүдийн адил эрхэлдэг аж. Эдгээр орнуудын хувьд нийтлэг байсан нэг зүйл бол нийгмийн салбарт эмэгтэйчүүдийн бөөгнөрөл үүссэн явдал юм. Ажиллах хүчинд эзэлж буй эмэгтэйчүүдийн хувь хэмжээгээр Их Британи хамгийн доод түвшинд байсан бол бусад орнууд нь түүнээс харьцангуй өндөр байсан байна. Нидерландад эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 1960 оныхос 2 дахин нэмэгдсэн байхад Германад 2 хувиар нэмэгдсэн байна (Кромптон. Р 1998, Пфау-Эффингэр. Б 1998).

Ийнхүү төрийн халамжийн ялгаатай бодлого бүхий орнууд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнээрээ ялгаатай дүр зураг бүхий байна. Эндээс төрийн халамжийн бодлого нь тухайн нийгэм дэх ЭМЭГТЭЙ

ХҮН, ХҮҮХДИЙН талаарх соёлын тодорхойлолт, ТЭЖЭЭГЧ хийгээд **ХАЛАМЖЛАГЧ**-ийн талаарх соёлын загвараас хамааран тогтдог бөгөөд энэ нь цаашлаад эмэгтэйчүүдийн олон нийтийн хүрээнд гарах уу, хувийн хүрээндээ үнэлгээгүй хөдөлмөрөө эрхлэх үү хэмээх асуудлын шийдэл, үнэлгээгүй хөдөлмөрийг үнэлгээжүүлж байгаа эсэх нь тодорхойлогдож байгаа нь харагдаж байна (Кромптон. Р 1998, Пфау-Эффингэр. Б 1998). Хэрэвзээ төрийн халамжийн бодлого нөхөр тэжээгч, эмэгтэй хүний гол дүр-үүрэг бол ЭХ байх явдал, **ХҮҮХЭД** бол ээжийн асрамжид гэрт өсөх ёстой гэсэн баримтлалыг хүчтэй тодорхойлдог патриархаль соёлын загварт тулгуурлалгүйгээр боловсруулагдан хэрэгжвэл жендерийн тэгш харилцааг тогтоох, жендерийн уламжлалт харилцааг өөрчлөхөд нөлөөтэй болохыг харж болох юм.

Тодруулбал либераль бодлогын хувьд хүүхэд асарсны тэтгэмж өгдөггүй, хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн мэдрэмжит зохицуулалт муу байдаг нь хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хөлстэй хөдөлмөр эрхлэхээс тодорхой хугацаанд татгалзах, цалингийн хэмжээ харьцангуй доогуур цагийн хөдөлмөр эрхлэхэд түлхдэг байна.

Корпоратист төрийн бодлоготой гэх Франц орны хувьд хүүхдийг төрүүлэх, асрахыг дэмждэг пронаталист бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сайнаар нөлөөлжээ. Р.Кромптон (1998) Францыг корпоратист бодлоготой бусад орнуудаас онцлог ялгаатай байна гээд Хүүхдийг дэмжсэн төрийн бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сайнаар нөлөөлсөн байна хэмээн дүгнэжээ. Харин корпоратист бодлоготой Германы төрийн бодлого эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг төдийлөн дэмжиж чадахгүй байгаа нь уг дүгнэлтийг баталгаажуулж байна.

Харин социаль демократ бодлого нь хөлстэй хөдөлмөрт ахиц дэвшил гаргаад зогсохгүй хөлсгүй хөдөлмөрийг үнэлгээжүүлэх тал дээр амжилт олж чадсанаар хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн тэгш байдлыг тогтоох үйл хэрэгт сайнаар нөлөөлдөг аж. Харин социалист байсан орнуудын хувьд хөлстэй хөдөлмөр дэх оролцоог нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч амжилт олсон атлаа хөлсгүй хөдөлмөрийг хэт орхигдуулсан төлөв байдлыг үүсгэдэг байна.

1990 оноос хойш манай улсын төрийн халамжийн бодлогод нэлээд өөрчлөлт гарсан тул өнөөгийн бодлого нь Е.Андерсений ангилалаар аль хэв маягт багтаж байгаа, эх, хүүхдийг дэмжих талаар юун дээр амжилт олж чадсан, юу нь учир дутагдалтай байна вэ гэдгийг тодруулахад анхаарлаа хандуулья.

Гурав. Монголын төрийн халамжийн бодлого

Монголын төрийн 20-р зууны бодлого нь эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь өөрчлөгдхөхөд онцгой нөлөө үзүүлсэн тухайд маргах зүйл байхгүй юм. Гэхдээ өrnөдийн судлаачид болон манай зарим судлаачид социалист орнуудын эмэгтэйчүүдийн талаар баримталж байсан бодлого нь илүү хөнгөвчлөх чиглэлийн, хөлстэй хөдөлмөрт хэт анхаарсан бодлого байсан хэмээн шүүмжилдэг (Берн. Н 2001).

МУ-д социалист систем нураад даруй 10 гаруй жил өнгөрөн, нийгмийн халамжийн бодлогын өнцөг ч нэлээд өөрчлөгдөөд байна. Иймээс өнөө цагийн ЭХ, **ХҮҮХДИЙН** талаар баримтлах төрийн бодлого нь Е.Андерсений тодорхойлсон хэв маягуудын алинд нь багтах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөө үзүүлж болох талаар энэхүү хэсэгт авч үзэх болно.

Section 2.01 Монгол Улсын Үндсэн Хуулинд (1992) хүүхэд төрүүлэх, асрахдаа тусламж авах эрхтэйг заасан билээ. Уг хуулинд заасан энэхүү эрх холбогдох бусад хуулиудад хэрхэн тусгагдан, эдлэх боломжийг хэрхэн олгож байна вэ гэдэгт юуны түрүүнд анхаарлаа хандуулья.

Нийгмийн халамжийн тухай хуулинд (2000) жирэмсний болон амаржсан, хүүхэд төрүүлсэн, нярай хүүхдийн арчилгаа, 0-1 насны хүүхдийн асаргаа, олон

хүүхэдтэйн буцалтгүй тусламж авах зэргээр хalamжийн үйлчилгээг хүртэх боломжийг бүх эмэгтэйчүүдэд тэгшээр олгосон байна. 0-1 насны хүүхэд асарсны тэтгэмж нь наг жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд хөдөлмөрийн хелсний доод хэмжээнд хүрч чадлагтүй. Хүүхэд асаргааны тэтгэмжийг эцэг бас авах боломжийг зааж өгсөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байсан буюу хөлстэй хөдөлмөр эрхлэж байсан эх жирэмсэний болон амаржсаны тэтгэмжийг төлж байсан шимтгэлийн хэмжээнээс хамааруулан авах аж. Хүүхдийг асрах хугацаанд байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлийг нь үргэлжлүүлэн төлөх замаар ажилласан жилд нь тасралт үүсэхгүй байна.

Харин хөлстэй хөдөлмөр эрхэлдэггүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эх хүүхдээ асарч байх үедээ нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байсан бол хөдөлмөрлөсөн жилд тооцоогоор тусгасан байна. Ийнхүү даатгалын шимтгэлийг төлж байсан эсэхзэс хамаарч байгаагаараа либераль бодлогын шинжийг тодорхой хэмжээгээр агуулж байна.

2004 онд Нийгмийн хalamжийн хуульд нэмэлт өөрчлөлт орсон нь 2005 оны 1-р сараас хэрэгжиж эхлээд байна. Уг нэмэлт өөрчлөлт ёсоор 3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн, хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэггүй, хүүхдээ сургуулиас хүүхдүүд бүрт сар бүр 3000 төгрөгийн тэтгэмж завсардуулаагүй, 18 нас хүртэлх хүүхэд бүрт сар бүр 3000 төгрөгийн тэтгэмж ядуу өрхүүдийн амьжиргааг дэмжин, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд зэрэгээр нөлөөлж буй хэрэг юм. Мөн түүнчлэн уг бодлого нь орлогын дахин хуваарилалт хийж буйн нэлээд чухал илрэл бөгөөд ийнхүү төр социаль демократ бодлогоор илүүтэй тодорхойлогдох болж байгааг харуулж байна.

1990-ээд оноос хойш хөдөлмөрийн хуулинд 0-3 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд 3 хүртэлх жилээр ажлаас чөлөөлгөх эрх бүхий болсонтой уялдан 0-2 насны хүүхдийг асрах ясли ажиллуулахыг төр дэмжихээ больсон байна. Мөн түүнчлэн 3-7 насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болох цэцэрлэгийн тоо 1990 оноос эхлэн буурч байснаа 2000 оноос хойш сургуулийн өмнөх боловсролыг олгохыг чухалчилснаар цэцэрлэгийн тоо өсөх болсон аж. Цэцэрлэгийг 9 сарын нэгнээс 6 сарын нэгэн хүртэл үргэлжлэн, өглөөний 8 цагаас эхлэн 8-10 цагийн хугацаанд ажиллахаар тогтоосон байна. Социалист төрийн үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх явдлыг хүүхдийн ясли, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх замаар онцгойлон дэмжиж байсан бол харин өнөө үед сургуулийн өмнөх боловсролыг чухалчлах бодлогын буянаар цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх болсон нь эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэхэд сайнаар нөлөөлөх нь гарцаагүй юм.

Хөдөлмөрийн тухай хуулинд ажилд авах үед эмэгтэйчүүдээс жирэмсэн эсэхийг асуухгүй байх, жирэмсэний болон амаржсаны амралтын үед ажлын байрыг нь хадгалах, эрэгтэй/эмэгтэй хүмүүс адил цалин авах, жирэмсэн эмэгтэй, найм хүртэл насны хүүхэдтэй ганц бие эхийг шөнийн цагаар ажиллуулахгүй байх, 0-1 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хүүхэд хөхүүлэх, асрахад нь зориулж түр чөлөө олгох, түүнийг нь ажилласнаар тооцох зэргээр хүүхэдтэй эмэгтэйчүүдийг дэмжин ажиллахыг хуульчлан зааж өгсөн байна. Энэ нь хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх эрхийг дэмжсэн, хөнгөлөлт үзүүлсэн, хамгаалсан төрийн бодлого оршин байна.

Дөрөв. Хэлэлцүүлэг ба дүгнэлт

Хүүхэд асрах үйл хэргийг төрд даатгахаас гэр бүлд даатгах бодлого руу шилжсэн шилжилт хийгдсэн болохыг та эмэгтэйчүүдийн хүүхэд асрах хугацааг сунгасан, 0-3 насны хүүхдийн асаргааны байгууллага болох яслийг татан буулгаснаас харагдаж байна. Мөн түүнчлэн эхчүүд/эцгүүд хүүхдээ нэг нас хүртэл нь хүүхэд асаргааны тэтгэмж авах эрхтэй болсон нь уг хөдөлмөрийг

үнэлгээжүүлэх тал дээр ахиц гарч байгааг харуулна. Хүүхэд асаргааны тэтгэмжийг хөлстэй хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй бүхий л эхчүүд/эцгүүд авах эрх бүхий байгаагаас социаль демократ бодлогын шинж илэрч байна.

Гэвч нөгөө талаас хараад басхүү либераль, корпоратист бодлогын шинжүүд зэрэгцэн илэрч байна. Учир нь корпоратист бодлогын шинж жирэмсний, хүүхэд төрүүлсний тэтгэмж нь төлж байсан шимтгэлийн хэмжээнээс хамаарч байгаагаар илэрч байхад, либераль бодлого нь хүүхэд асрах хугацаанд хувь хүн өөрөө эсвэл байгууллага нь нийгмийн даатгалд хамруулж байгаа эсэхээс хөдөлмөрлөсөнд тооцогдох эсэх нь тодорч байна. Нийгмийн халамжийн бодлогын энэхүү хэсгээс хараад хөлстэй хөдөлмөр эрхэлж байсан эмэгтэйчүүдийн хувьд хүүхэд асрах хөдөлмерийг үнэлгээжүүлж буй дэвшлийг илүү байгууллагаараа дамжуулан мэдрэх боломжийг олгожээ. Энэ нь хөлстэй хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлсний дараах 1 жилийн хугацаанд гэрийн хөдөлмөр лүү түлхэх нэхцлийг агуулж байна.

ЭХ/ХҮҮХДИЙГ дэмжсэн шинжтэй заалтууд нэлээдгүй байгаа ч, дэмжсэн гэж үзэхэд төвөгтэй байна. Учир нь хүүхэд асрах нь 1 жилийн хугацаанд хөлстэй мэт харагдавч, түүний хэмжээ нь хэт бага байна. Энэ нь эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлсний дараагаар хурдан ажилдаа эргэн орох явдалд нөлөөлөх талтай. Энэ нөлөө нь нийгмийн анги, давхраануудад ялгаатайгаар илэрч болох юм.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхед олгох олон хүүхэдтэй тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь социаль демократ бодлогын шинжийг илүүтэй агуулж байна. Учир нь даатгалд хамрагдсан эсэхээс үл хамаарсан шинжтэй бөгөөд “төр тэжээгч”-ийн үүргийг нэн ядуу, ядуу өрхийн хүүхдүүдийн өмнө хүлээж байна. Гэхдээ төрийн тэжээгчийн энэхүү үүргийг зөвхөн нэн ядуу, ядуу өрхийн хүүхдүүд мэдрэхээр тогтоогдсон нь ядуу давхрааныхныг хамгаалахад чиглэгдсэний зэрэгцээгээр зөвхөн тэдгээрийн төрөлтийг дэмжсэн бодлогын шинжийг агуулж байна гэж үзэх үндэслэлийг олгож байна. Дахин тодруулбал олон хүүхэдтэйн тэтгэмж төдийгүй нярай хүүхдийн асаргааны тэтгэмж зэргийг зөвхөн ядуу өрхийн хүүхэд авах эрхтэй байгаа нь төр уг давхрааны хүүхдийг ивээлдээ авч, нийгмийн бусад давхрааны хүүхэд эцэг эхийн ивээлд байхаар тогтоож байна. Үүнтэй холбоотойгоор уг бодлогын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө нь нийгмийн давхраануудын хувьд ялгаатай нөлөөг үзүүлж болохыг нөхцөлдүүлж байна. Учир нь: ядуу давхрааныхны хувьд “төр тэжээгч” загвар тодорхой хэмжээгээр үйлчилж байгаа нь эмэгтэйчүүдийг хөлстэй хөдөлмөр эрхлэхээс татгалзах, харин бусад давхрааныхны хувьд “эцэг эх тэжээгч” загвар үйлчилж байгаа тул эмэгтэйчүүд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд түлхэх гэсэн ялгаатай нөлөөллийг үзүүлж болох юм.

0-3 насны хүүхдийн асаргааны байгууллага болох ясли устсан нь социалист төрийн “төр халамжлагч” загвар буурах болсныг харуулна. Энэ нь З-оос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд гэртээ үлдэж хүүхдээ асрах эсвэл гэр бүл ойр дотны хүмүүс, хувийн секторт найдах гэсэн сонголтыг тулгаж байна. Гэхдээ монгол эцэг эхчүүдийн дунд “Хүүхэд цэцэрлэгээр хүмүүжих нь сайн” гэсэн үзэл баримтлал хүчтэй. Төрийн цэцэрлэгүүд нь зөвхөн “хоолны” гэх төлбөрийг маш бага хэмжээтэйгээр авдаг нь эцэг эхчүүдэд дарамт авчирдаггүй. Энэ нь З-аас дээш насны эмэгтэйчүүдэд хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж байна. Гэхдээ зуны хугацаанд (6-9 саруудад) төрийн цэцэрлэгүүд ажилладаггүй тул гэр бүлүүд энэ хугацаанд хүүхдээ хэн асрах вэ гэсэн асуудалтай тулгардаг. Энэ нь уг хугацаанд ээлжийн амралтаа авах, ажлаасаа чөлөө авах, ойр дотны хүмүүс, хувийн секторт хандах гэсэн шийдлүүдийг тулган хүлээлгэж байна. Энэхүү хэрэгцээг хувийн секторууд сорогоор мэдэрч зуны цэцэрлэгүүд, өдөр өнжүүлэхийг ажиллуулдаг болсон. Монголчуудын нийгмийн харилцаанд төрөл садан, ах дүүсийн холбоо харилцаа хүчтэй байдаг нь уг асуудлыг шийдэхэд аятай нөхцлийг бүрдүүлдэг. Нөгөө талаас хүүхдийн

асаргааны байгууллагын түр зогсолт нь эмэгтэйчүүдийг уг хугацаанд амралт, завсарлалт нь таардаг хөдөлмөрийн тэрлүүдийг эрхлэхэд түлхдэг байж болох юм. Жишээлбэл, боловсролын салбарт ажиллагсдын хувьд уг хугацаанд амардаг тул эмэгтэйчүүдэд уг салбарт ажиллах нь үнэлгээгүй хөдөлмөрөө зэрэгцүүлэн эрхлэх боломжийг олгодгоороо таатай болж байна.

Эцэст нь дүгнэхэд, төрийн халамжийн бодлогод социаль демократ бодлогын шинжүүд түлхүү илэрч байгаа хэдий ч, зарим талаар либераль, корпоратист бодлогын шинжийг агуулж байгаа тул холимог шинжтэйгээр төлөвшиж байгаа юм байна. Халамжийн бодлогын үзэл баримтлалын өөрчлөлт нь дээрх З хэв маягийн аль нэгийг гэхээс илуу “зах зээл өндөр хөгжсөн” орнуудын бодлогын олслттой талуудаас өөрийн орны нөхцөлд тохируулан шинэчлэх гэсэн хандлагатай байна.

Энэхүү бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд 2 талтайгаар нөлөөлөх болов уу гэж таамаглахад хүргэж байна. Нэг талаас 3-оос доош насын хүүхэд асаргааны байгууллагыг төр дэмжихгүй байгаагийн зэрэгцээ хүүхэд асаргааны (0-1 насын) тэтгэмж хэт бага байгаа явдал нь нэгд, эмэгтэйчүүдийг эх байх, хоёрт, нөхөр нь тэжээх ёстой баримтлалыг агуулж байна. Ийм баримтлалаар тодорхойлогдсон бодлого нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөөтэй байдаг (Пфау-Эффингэр. Б 1998).

Нөгөө талаас тэтгэмжийн хэмжээ хэт бага, 3-оос дээш насын хүүхдийн СӨНХ-ийн боловсролын систем бэхжсэн, 1-ээс дээш жилийн хүүхдийн асаргаа ажилласан жилд тооцогддоггүй байдал нь эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн түвшинд сайнаар нөлөөлнө. Энэ талаас нь авч үзвэл манайд “хоёул тэжээгч” загвар түгээмэл илэрч байгааг буюу гэр бүлийн төсөвт эмэгтэйчүүдийн орлого чухал байгааг харуулна.

Хүүхдийг ивээх төрийн бодлого нь нийгмийн анги давхрааныхны хувьд адил бусаар олгогдож байгаа явдал нь эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд анги давхраанаас хамаарсан шинжтэйгээр ялгаатайгаар нөлөөлөхийг нөхцөлдүүлж байна.

Ер нь төрийн халамжийн бодлогын хувьд хүүхдийн асаргааны хөдөлмөрт хэт бага хөлс өгч байгаа явдал нь үнэлгээгүй хөдөлмөрийг үнэлгээжүүлэх тал дээр учир дутмаг байгааг илтгэх бөгөөд нэг талаас эмэгтэйчүүдийг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд хүчтэй түлхэж байгаа нь сайшаалтай ч, нөгөө талаас эмэгтэйчүүдэд үнэлгээгүй хөдөлмөрийг нуруундаа үүрэхийн зэрэгцээ хөлстэй хөдөлмөр эрхлэх давхар ачааллыг үүрүүлэхэд хүргэж байна. Энэ нь “Давхар ачаалалтай эмэгтэйчүүд” бүхий социалист төрийн үргэлжлэл болон оршсоор байгаагийн ипрэл юм.

(i) Ном зүй

1. Bjoernberg U, (2002) Ideology and choice between work and care: Swedish family policy for working parents. *Critical Social Policy* 22, 1 pp 33-52
2. Crompton, R. (1998) 'Women's Employment and State Policies' *Innovation* 11(2)
3. Duncan, S. (2000) 'Introduction: Theorising comparative gender inequality' in Duncan S and Pfau-Effinger, B. (eds) *Gender, Economy, and Culture in European Union* London, Routledge
4. Duncan, S and Strell, M. (2001), 'Lone Motherhood, ideal type care regimes, and the case of Austria' *Journal of European Social Policy* 11 (2)
5. Duncan, S, Williams, F. (2005) (draft) New Cross-National Perspectives on Gender Equality, Care and Paid Work. *Critical Social Policy*
6. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк. (хэвлэгдээгүй) (2004). Монгол улс дахь жендерийн асуудлууд. Улаанбаатар.

7. Esping Andersen, G. (1990) *The Three Worlds of Welfare Capitalism* Cambridge, Polity.
8. Ferge Z. (1998) Women and social transformation in central Europe: the old left and the new right, 217-237 in *Social Policy Review* 10
9. Gazsi, J., hars, A., Juhasz B., Peto, A., Szabo, S. (2004) *Hungary*.
10. НҮБХХ, СЭЗЯ. (2004) Нийгмийн хамгаалалын салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгөд хийсэн жендэрийн дүн шинжилгээ. Улаанбаатар
11. НҮБЭХ. (2001) Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй. Улаанбаатар хот
12. Pollert A (2003) 'Women, work and equal opportunities in post-Communist transition' *Work Employment and Society* 17, 2, 331-57.
13. УИХ. (2003) Хууль тогтоомжуудын эмхэтгэл /CD/, Улаанбаатар
14. Walby, S. (1994), 'Methodological and theoretical issues in the comparative analysis of gender relations in Western Europe' *Environment and Planning*

1) Abstract

This article covers relation between welfare state and women's employment in Mongolia. It presents firstly, the conclusions of comparative studies and theoretical concepts of western researchers on the issue and secondly, the definition of type of Mongolian Welfare State and how affects of welfare state on women's employment in Mongolia.